# УБ ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ II ДАХЬ ТӨСӨЛ

# 2007 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН
# 2008 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ

## ГАРЧИГ

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР** ........ 2

**1. ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (ОУХА)-ИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ** ........ 4

**ТӨСЛИЙН НЭР** ........ 4

**САЛБАР** ........ 4

**ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА** ........ 4

**ТӨСЛИЙН ЗОРИЛГО** ........ 4

**ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД** ........ 4

**ТӨСЛИЙН ҮР ШИМ, АЧ ХОЛБОГДОЛ** ........ 5

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ (САЯ АМ. ДОЛЛАР)** .. 6

**ТӨСЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗүЙН ОРЧНЫ БҮРДЭЛТ** ........ 6

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ** ........ 6

**2007 ОНД ХИЙЖ ГүЙЦЭТГЭСЭН АЖЛУУД** ........ 7

**ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРЧ БАЙГАА ХҮНДРЭЛҮҮД** ........ 14

**ДҮГНЭЛТ** ........ 15

**2. ЯПОНЫ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН САН (ЯНХС)-ИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ-TF 05382017**

**БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН НЭР:** ........ 17

**ЗОРИЛГО:** ........ 17

**ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ:** ........ 17

**ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:** ........ 17

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ:** ........ 17

**ХИЙГДСЭН АЖЛУУД:** ........ 17

**ДҮГНЭЛТ** ........ 17

**3. 2008 ОНД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА АЖИЛ /ЗЭЭЛ, ТУСЛАМЖ БҮРЭЭР/** ........ 18

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УБНААСТ1-Улаанбаатар  хотын Нийтийн аж ахуйг сайжруулах 1 дэх төсөл

УБНААСТ2-Улаанбаатар  хотын Нийтийн аж ахуйг сайжруулах 2 дахь төсөл

ОУХА-Олон Улсын Хөгжлийн Ассоциаци

ДБ-Дэлхийн банк

НЗДТГ-Нийслэлийн Засаг даргын тамгын газар

ЗАА-Захирагчийн ажлын алба

УСУГ-Ус сувгийн удирдах газар

ТУН-Төслийг удирдах нэгж

ТХН-Төсөл хэрэгжүүлэх нэгж

ТУХ-Төсөл удирдах хороо

ДЗГ-Дамжуулан зээлдүүлэх гэрээ

ТГ-Төслийн гэрээ

УТБ-Ус түгээх байр

АОС-Амины орон сууц

НӨАТ-Нэмүү өртгийн албан татвар

ХХЯХ-Хүчитгэсэн хуванцар яндан хоолой

ЗШХ-Зөөлөн ширмэн хоолой

ОСНААГ-Орон сууц нийтийн аж ахуйн газар

СӨХ-Сууц өмчлөгчдийн холбоо

| **1. Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн хөнгөлөлттэй зээл** | |
|---|---|
| **Төслийн нэр** | Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төсөл (УБНААС2) |
| **Салбар** | Нийтийн аж ахуйн салбар |
| **Төслийг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага** | Монгол улсын Засгийн газар Дэлхийн банкнаас "Гэр хорооллын иргэдийг стандартын шаардлагад нийцсэн, чанартай усаар тасралтгүй хангахад шаардагдах дэд бүтцийг хөгжүүлэх"-д шаардлагатай хөрөнгө оруулалтын туслалцааг хүссэний дагуу эхний шатны (УБНААСТ1) төслийн адил, хоёрдугаар шат болох УБНААСТ2 төслийг хэрэгжүүлэхэд зориулж 18 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийг авсан.<br>Усны салбарт хэрэгжүүлэх төслийн гол асуудлууд нь: а/ гэр хорооллын НАА-н үйлчилгээг сайжруулах зайлшгүй шаардлага; б/ хотын төвлөрсөн сүлжээний усны алдагдлыг багасгах; в/ үнэ тарифийн шинэчлэл хийх замаар усны нөөцийг хамгаалах; г/ зардлыг багасгах, зардлаа бүрэн нөхөх замаар салбарын санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Мөн ус хангамжийн найдвартай байдал, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, НЗДТГ-ын удирдлага, санхүүжилт зэрэг чухал шаардлагатай хэсгүүдэд хөрөнгө оруулалтыг хийх замаар хотын хөгжлийг дэмжинэ. |
| **Төслийн зорилго** | Төслийн тэргүүн зэргийн зорилго нь "Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдад стандартын шаардлагад нийцсэн ус хангамжийн үйлчилгээг хүргэх, найдвартай, тогтвортой болгох" |
| **Төслийн хүрээнд хийгдэх ажлууд** | Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төсөл 2004-2010 онд хэрэгжинэ. Дотоод санхүүжилт болох 4.98 сая ам. долларыг оруулан төслийн нийт өртөг 22.98 сая ам. доллар.<br>Гэрээний дугаар: 3890-MOG,<br><br>**Төсөлд дараахи гэр хорооллууд хамрагдана**.<br><br>❑ Чингэлтэй /Чингэлтэй дүүрэг/<br>❑ Дамбадаржаа /Сүхбаатар дүүрэг/<br>❑ Баянхошуу /Сонгино Хайрхан дүүрэг/<br>❑ Дарь-Эх /Баянзүрх дүүрэг/<br>❑ Наран /Баянгол дүүрэг/<br>❑ Улиастай /Баянзүрх дүүрэг/<br><br>Төсөл 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.<br><br>1. Гэр хорооллын ус хангамж<br>(1) 78.3 км шугам хоолойг ханган нийлүүлж, суурилуулах; Үүнд: Баянхошуунд 42 км, Чингэлтэйд 13 км, Дамбадаржаа-Дарь-эхэд 23.3 км, нийт 78.3 км шугам хоолой суурилуулах, одоо байгаа 82 УТБ, шинэ 22 УТБ, нийт 104 УТБ-ыг хотын сүлжээнд холбох;<br><br>(2) 3 усан сан, 3 насосны станц шинээр барьж, 104 ус түгээх байрыг шинээр барих буюу засварлах; Эмнэлэг, сургууль зэрэг 17 байгууллага, 430 айл өрхийг цэвэр усны шугамд холбох;<br><br>(3) Усны тоолуур, хаалт, насосуудыг холбогдох цахилгаан тоног төхөөрөмжийн хамт ханган нийлүүлж, |

| | |
|---|---|
| | суурилуулах;<br><br>(4) 15 ус зөөврийн машин, бохирын 5 машин, тэдгээрийн сэлбэг хэрэгслийг ханган нийлүүлэх;<br><br>2. <u>Хотын ус хангамжийг сайжруулах</u><br>(1) Хотын шугам сүлжээний 12.2 км урт яндан хоолойг солиход шаардагдах шинэ технологийг нэвтрүүлэх;<br><br>(2) Баруун дүүргийн насосны станцын 4 насос, тоног төхөөрөмжийг солих; Телеметрийн системийг сайжруулах; Хяналтын цооног барих; лабораторийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх;<br><br>3. <u>Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх</u><br>Гүний 90 орчим насос; Дээд эх үүсвэрт 1,000 киловатын трансформатор болон хяналтын систем; Дээд, Төвийн, Мах комбинатын эх үүсвэрүүдэд 59 км агаарын шугамыг тус тус ханган нийлүүлж суурилуулах;<br><br>4. <u>Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох ба Төслийн менежмент</u><br>(1) Инженерийн нарийвчилсан зураг төсөл хийх, сонгон шалгаруулалтын бичиг баримт бэлтгэж, сонгон шалгаруулалтыг явуулах; барилгын ажлын хяналт, менежмент, чанарын хяналт хийх зэрэгт Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх;<br><br>(2) Бодлогын хүрээнд: олон нийттэй харилцах; санхүүгийн дотоод хяналт; айл өрхийг шугамд холбож, тоолууржуулах; ариун цэврийн байгууламж; УТБ болон зөөврийн ус хангамжид хувийн секторын оролцоо; эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх; үйл ажиллагааны зардлыг багасгах зэрэгт Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх |
| **Төслийн үр шим, ач холбогдол** | • Гэр хорооллын нөхцөл сайжирч ирээдүйд амины орон сууц (АОС) болон хөгжих нөхцөл бүрдэх.<br>• УСУГ-ын үйл ажиллагаа, менежментийг бэхжүүлэх.<br>• Хувийн секторын оролцоог ус түгээх байрууд болон ус зөөврийн машиныг хувьчлах замаар нэмэгдүүлэх.<br>• Шугам сүлжээн дэх усны алдагдал бууруулах.<br>• Телеметрийн систем, хяналтын хаалтууд, эрчим хүчний үр ашигтай тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлснээр ашиглалтын зардлыг бууруулах.<br>• Усны хүрэлцээ, шугам сүлжээний найдвартай байдлыг сайжруулах.<br>• Гэр хорооллын айл өрх, албан байгууллагууд ус хангамжийн системд холбогдох.<br>• Гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээний болон төлбөр дэх ялгаа багасах.<br>• Гэр хорооллолд уснаас үүдэлтэй өвчний өвчлөл буурах.<br>• Хотын хуучин шугам сүлжээг засварлах шинэ технологи нэвтрэх. |

| | |
|---|---|
| **Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ** (сая ам. доллар) | Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл-*18 сая ам. доллар*<br>НЗДТГ-аас ТУН-ийн үйл ажиллагааны зардлын 50%, Нүүлгэн суурьшуулалтын нөхөн олговорт нийт- *0.57 сая ам. доллар*<br>УСУГ-аас барилгын ажлын 67%, ТХН-ийн зардалд-*4.41 сая ам.доллар*<br><br>Бүгд: 22.98 сая ам.доллар |
| **Төслийн хууль эрх зүйн орчны бүрдэлт** | Монгол улс, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд Хөгжлийн зээлийн гэрээ 2004 оны 7-р сарын 23-нд байгуулагдаж, Улсын их хурлаар 2004 оны 10-р сарын 22-ний өдөр соёрхон батлагдсан.<br>❖<br>Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол 2004 оны 11-р сарын 01-ний өдөр гарч НЗДТГазар болон Дэлхийн банкны ОУХА-ийн хооронд байгуулсан Төслийн гэрээ батлагдаж, Засгийн газар болон НЗДТГ-ын хооронд, мөн НЗДТГ болон УСУГ-ын хооронд Дамжуулан зээлдүүлэх гэрээ ДЗГ) байгуулах үүрэг Хотын захирагчид өгөгдсөн.<br>❖<br>2004 оны 11-р сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын захирамж гарч ДЗГ-үүдэд гарын үсэг зурах эрх батламжлагдсан.<br>❖<br>УСУГ-ын ДЗГ-нд жилд 5%-ийн хүүтэй 10/40 жилийн хугацаатай байхаар тусгасан. Мөн НААС1 төслийн ДЗГэрээний хугацаа нь 5/20 байсныг 10/40 жил болгож өөрчлөлт оруулсан тухай шийдвэрийг Дэлхийн банкны Зүүн өмнөд ази, Номхон далайн бүсийн Монгол улсыг хариуцсан захирал 2005 оны 4-р сарын 8-ны албан тоотоор ирүүлсэн.<br>❖<br>Нийслэлийн засаг даргын 2005 оны 7-р сарын 15-ны өдрийн 1/1286 тоот зөвлөмж гарч усны үнэ тарифийг шинэчлэн 2005 оны 9-р сарын 1- ээс эхлэн нэмэгдүүлэв.<br>❖<br>Дэлхийн банкны 2005 оны 11-р сарын 29-ны өдрийн зөвшөөрлөөр УБНААС 2 төслийн худалдан авах ажиллагааны хөрөнгө зарцуулах эрх нээгдсэн.<br>❖<br>Дэлхийн банкны шаардлагын дагуу ТУН-ын ажилтнуудыг дотоодын зөвлөхийн статусаар ажиллуулж, аливаа татварыг зээлээс санхүүжүүлэхгүй байхаар хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулан 2007 оны 9-р сарын 1-ээс мөрдөж эхлэв. |
| **Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө** | Гэр хорооллын ус хангамжийн системийг сайжруулснаар шууд ба шууд бус хэд хэдэн эерэг нөлөөллийг байгаль орчинд үзүүлнэ.<br>• Гэр хорооллын иргэдийн усны чанарыг сайжруулснаар өвчлөл буурах, эрүүл ахуйн нөхцөл дээшлэх зэрэг нийгмийн ач холбогдолтой.<br>• УТБ-дад төвлөрсөн шугамаар ус хангамжийн үйлчилгээ үзүүлснээр стандартын шаардлага хангасан, баталгаатай ундны ус хэрэглэх боломж нэмэгдэнэ. |

| | |
|---|---|
| | • Нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжирснаар цаг хугацаа хэмнэгдэж ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх боломж нээгдэнэ. |
| **2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд** | **1. Худалдан авах ажиллагааны хүрээнд**<br>• Худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөг Дэлхийн банк, УСУГ-тай хэлэлцэн эцэслэв.<br>• “Барилгын ажлын хяналт, төслийн менежмент”-TA-02, гэрээний ажлын удирдамжийг боловсруулж, ашиглагч байгууллагаас саналыг эцэслэн Дэлхийн банкинд хүргүүлэн зөвшөөрөл авсан.<br>• Барилгын ажлын 2, Зөвлөхийн үйлчилгээний 2 тендерийн баримт бичгийг боловруулан, зарлах, үнэлэх, гүйцэтгэгч/зөвлөх компанийг шалгаруулах ажлыг хийж 2007 онд 9 гэрээнд гарын үсэг зурах бэлтгэл ажлыг хангав.<br>• Худалдан авах ажиллагааны явцад гарсан гомдлын талаархи мэдээллийн бүртгэлийг бий болгов.<br>• Гэрээний бичиг баримтын хавтаст хэргийг цэгцэлж, хавтас бүрийн товч мэдээллийг бүрдүүлэлтийн дэс дараалалд оруулав.<br><br>**2. Гэрээнүүдийн хэрэгжилтийн талаар**:<br>2007 оны 5-р сарын дундаас эхлэн барилгын Ерөнхий болон туслан гүйцэтгэгч нийт 9 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Барилгын ажил дараахи хэсгүүдэд явагдаж байна. Үүнд:<br>1. Баянхошууны гэр хорооллын өмнөд, хойд хэсэгт цэвэр усны шугамын угсралт, УТБ-ны барилгын ажил, Гэрээ BNSC-01;<br>2. Чингэлтэйн гэр хороололд цэвэр усны шугамын угсралт, УТБ-ны барилгын ажил, Гэрээ CTC-01A;<br>3. Чингэлтэйн гэр хороололд усан сан, насос станцын барилгын ажил, Гэрээ CTC-01B;<br>4. Усны чанар, бохирдлыг хянах зорилго бүхий гүний 3 худгийг өрөмдөж барилга барих, 6 хуучин худгийг лайдаж хяналтын худаг болгон ашиглах, Гэрээ CAC-04;<br>5. Зөөврийн 10 машин багтаах хүчин чадалтай гаражийн барилгыг ус, дулаан, цахилгаан хангамж, бохирын цооногийн хамт барьж байгуулах, Гэрээ KSC-01A;<br>6. Зөөврийн 10 ш ус түгээх байрыг усны хэрэгцээт хэд хэдэн байршилд барьж байгуулах ажил, Гэрээ KSC-01B;<br>7. Баруун дүүргийн насос станцын одоо ажиллаж байгаа 3 насосыг эрчим хүчний хэмнэлттэй насосоор сольж, хаалт арматурыг шинэчлэх ажил, Гэрээ CAC-01<br><br>Дээрх гэрээнүүдийн хүрээнд хийгдсэн ажлыг тоогоор илэрхийлбэл:<br>• Баянхошуу өмнөд хэсэгт 10 км шугам суурилуулахаас 4.8 км-ийг<br>• Баянхошуу хойд хэсэгт 10 км шугам суурилуулахаас 7.1 км-ийг<br>• Чингэлтэйд 13 км шугам суурилуулахаас 8.2 км-ийг тус тус суурилуулаад байна.<br>• Мөн усан сангийн барилгын ул, хана, хучилтыг бүрэн цутгаж, халаалтын байрны суурийг хийгээд байна. Барилгын ажлын гүйцэтгэл усан сангийн хувьд 70%-тай байна.<br>• Зөөврийн ус түгээх 10 байрны барилгын ажлын гүйцэтгэл |

| | |
|---|---|
| | 80%-тай байна.<br>• Баруун дүүргийн насос станцын насос, хаалт, арматур шинэчлэлтийн ажил 20 гаруй хувьтай байна.<br>• Ашиглалтад хүлээлгэн өгсөн 1 барилга байгууламж байгаа ба энэ нь усны 10 машины гаражийн барилга юм.<br>Гэрээ тус бүрийн хэрэгжилтийг биелэлттэй нь харьцуулж хавсралт №1-д үзүүлэв.<br><br>БУА-д дараахи байгууллагууд хяналт тавьж ажиллаж байна.<br>a) Төсөл хэрэгжүүлэх нэгж-Энэхүү нэгж нь УСУГ-ын дэргэд байгуулагдсан, барилгын ажилд өдөр тутмын хяналт хийж Захиалагчийн үүрэг гүйцэтгэдэг.<br>b) Төслийг удирдах нэгж- Хяналтын инженерүүдээрээ дамжуулан барилгын ажлын хугацаа, материал зарцуулалт, газар зохион байгуулалтад хяналт тавьдаг.<br>c) Зөвлөх компани- Барилгын ажил нь зураг төсөл, техникийн тодорхойлолтын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж шаардлагатай үед ТУН, ТХН-д удирдлагын, чанарын, хөдөлмөр хамгааллын, техник технологийн чиглэлээр зөвлөгөө өгдөг.<br>d) Зохиогчийн хяналт-Барилгын зураг төсөл боловсруулсан байгууллагуудтай зохиогчийн хяналтын гэрээ байгуулан ажиллаж байгаа ба шаардлагатай үед зурагт өөрчлөлт оруулдаг.<br>e) Мэргэжлийн хяналтын байгууллагууд-Эдгээр байгууллагууд нь өөрсдийн төлөвлөгөөт хуваарийн дагуу эсвэл ТУН, ТХН-ийн хүсэлтийн дагуу бусад хөндлөнгийн хяналт хийдэг.<br><br>**3. Нүүлгэн суурьшуулалтын талаар**:<br><br>• Баянхошуу, Чингэлтэйн гэр хорооллын шугамын угсралтын ажлыг хэвийн явуулах нөхцлийг хангах үүднээс нүүлгэн суурьшуулалт, газар зохион байгуулалтын талаар дараахи арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>o 142 хашааг түр буулгаж, буцааж барьсан<br>o Нүүлгэн шилжүүлсэн өрхийн тоо-1<br>o Нүүлгэсэн байшин-1<br>o Татсан хашааны тоо-1<br>o Зургийн зохиогчоор зурагт өөрчлөлт оруулах замаар нүүлгэн шилжүүлэлтээс чөлөөлсөн-9<br>o Техник зохион байгуулалтын арга хэмжээ авсны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэлт хийгдээгүй айл өрхийн тоо-10<br>o Насос станц, усан сан баригдах газар суурьшсан айл өрхийн нөхөн олговрын асуудлыг Нийслэлийн өмчийн газарт тавьж материалыг бүрдүүлж өгсөн<br><br>• Нийслэлийн авто замын газраас авч хэрэгжүүлж байгаа авто замын шинэчлэлтийн ажлуудтай төслийн ажлыг уялдуулахад анхаарч, зурагт тусгуулах, барилгын ажлын явцад технологийн уялдуулга хийх зэргээр хамтарч ажиллаж байна.<br>• Гэр хороололд цэвэр усны шугам суурилуулахын ач холбогдол, түүнээс хүртэх үр шимийг иргэдэд зөв ойлгуулах зорилгоор телевизээр 2 удаа нэвтрүүлэг хийж олон нийтэд түгээсэн. |

| | |
|---|---|
| | • Мөн УТБ-уудад шугамын трасс, худгийн байршлыг харуулсан 24 самбарыг байрлуулсан.<br><br>**4. Зээл тусламжийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны талаар:**<br>• 2008-2010 оны төслийн санхүүжилтын төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны шинэчлэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан Дэлхийн банк, УСУГ, НЗДТГ тус бүрийн гаргах хувь болон мөнгөн дүнтэй нь шинэчлэн гаргаж дэлхийн банкинд явуулсан. Мөн сангийн яаманд хүргүүлсэн<br>• 2008 оны ТУН-ийн төсвийн төлөвлөгөөг гарган, НИТХ-д оруулж батлуулсан<br>• УБНААС2-ийн зээлийн зарцуулалтын байдалд “Далай Ван”ХХК-иар аудит хийлгэсэн.<br>• 2006-2007 онуудад төслийн хөрөнгөөр хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавьж нийт 36 удаагийн төлбөрийг сангийн яам, дэлхийн банкаар баталгаажуулан хийсэн.<br>• Төслийг удирдах нэгжийн ажиллагсдын даатгалын төлөлтийг Дэлхийн банкны шаардлагын дагуу сайн дурынх болгон өөрчилж 2007 оны 9-р сараас эхлэн мөрдсөн<br>• ТУН-ийн ашиглаж байсан, ажлын шаардлага хангахгүй болсон автомашин, компьютер тоног төхөөрөмжийн Нийслэлийн өмчийн газар хүлээлгэн өгч данснаас хасагдуулга хийлгэсэн.<br>• 2006-2007 оны санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын албанаас шалгалт хийсэн. Шалгалтаар зөрчилгүй гарсан.<br>• Мөн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын алба, Чингэлтэй Дүүргийн Нийгмийн даатгалын газраас нийгмийн даатгалын төлөлтөнд шалгалтыг хийсэн. Шалгалтууд зөрчилгүй гарсан.<br>• Мөн буцалтгүй тусламжаар хийгдэж байгаа төслүүдийн санхүүгийн тайланг дэлхийн банкинд гаргаж өгч байв. Үүнд: ЯНХС(TF053820); НЗДТГ-ын хүний нөөцийг сайжруулах, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх (TF053622)<br>• 2007 онд Зээлийн гэрээний зарцуулалтыг төлөвлөлттэй нь харьцуулбал:<br>  o Ажлын хувьд..............<br>  o Барааны хувьд............<br>  o Үйлчилгээний хувьд............<br>  o Нийт дүнгээр нь авч үзвэл:..............<br><br>Санхүүгийн тайланг хавсралт 2-т үзүүлэв.<br><br>**5. Мэдээлэл сурталчилгааны ажлын талаар**<br><br>Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах төслийн зорилго, чиглэл, үйл ажиллагааг иргэдэд ойлгуулан таниулах, гэр хорооллын нийтийн аж ахуйн өнөөгийн байдал, цаашид хэрхэн сайжруулах арга замыг иргэдийн өөрсдийнх нь санал санаачлагад тулгуурлан тодорхойлох, усны чанар, стандарт, эх үүсвэр, зөв зохистой хэрэглээний талаар мэдэээлэл өгөх үүднээс мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг төлөвлөгөөтэй хийв.<br><br>Сурталчилгааны ажлын стратеги, төлөвлөгөө боловсруулах |

| | |
|---|---|
| | болон гарсан төлөвлөгөөний дагуу мэдээлэл сурталчилгааны ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чадах компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. Сурталчилгааг дараахи хэлбэрүүдээр өргөн хэмжээнд зохион байгуулав. Үүнд:<br>• Телевизтэй гэрээ байгуулан, сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэв.<br>o С1 телевизтэй гэрээ байгуулан "Бидний мэдэхгүй Улаанбаатар", "Унагалдайн мухлаг" гэсэн булангуудаар нийт 13 нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээсэн<br>o УСУГ, ОСНААУГазартай хамтран Монгол телевизийн Үдшийн хэмнэл студи-ээр усны үнэ цэнэ, ач холбогдол, нөөцийн хомсдолын талаар 5 нэвтрүүлэг бэлтгэн цацсан.<br>• Радиотой гэрээ байгуулан, сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэв,<br>o УБ радиотой хамтран 7 нэвтрүүлэг, Монголын үндэсний олон нийтийн радиогийн Гурван эрдэнэ студитэй хамтран 1 нэвтрүүлэг хийж олон нийтэд түгээсэн.<br>o Мөн 4 төрлийн богино хэмжээний сурталчилгааны хэлбэр "шторк"-ийг хийж олон нийтийн оролцоотойгоор орчноо хөгжүүлэх санал санаачлагыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан.<br>• Сонингоор дамжуулан олон нийтэд мэдээлэл өгөв.<br>o Усыг зөв зохистой хэрэглэх, хайрлан хамгаалах талаар сурталчилсан 4 сонин гаргаж, СӨХ-өөр, шуудангийн хайрцгаар, сонингийн хавсралт маягаар, сургууль цэцэрлэгээр дамжуулж тус тус тараасан.<br>• Сэтгүүлчидтэй хамтран УБ-НААСТ хэрэгжиж байгаа барилга обьектууд болон цэвэр усыг түгээж, бохир усыг татан зайлуулдаг ашиглагч байгууллага (УСУГ)-ын талаар, халуун хүйтэн усыг хэрэглэгчдэд түгээдэг ОСНААГ-ын үйл ажиллагааны талаар зөв, тодорхой ойлголт өгөх зорилгоор 3 удаа аялал зохион байгуулав.<br>• Байгууллагын веб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл өгөхийн тулд цаг тухайд нь шинэчлэх арга хэмжээ авч байна.<br>• Усны зөв зохистой хэрэглээнд сургах, арвилан хэмнэх сэтгэлгээг иргэдэд олгох зорилготой сурталчилгааны самбар 3 хийж хүн ам олноор цугладаг газар байрлуулах<br>• Төсөл хэрэгжсэний 10 жилийн ойн арга хэмжээнд зориулж баримтат кино хийсэн. |
| | **6. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан ТУН-ийн захирлын гэрээний биелэлтийн талаар**<br><br>Бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажлын талаар авсан 9 тооны үүрэгт ажлыг 100 хувь биелүүлсэн. Үүнд:<br><br>• Гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээнд суурилагдах 70 гаруй км шугам хоолой, .........ш хаалт арматур, ..... ш насос дагалдах холбох хэрэгсэл, цэвэр бохир усны 15ш машин зэргийг Ханган нийлүүлэгч байгууллагаас татан авсан |

- Баянхошуу, Чингэлтэйн гэр хорооллуудад шугамын барилга байгууламжийн ажлыг, Баруун дүүргийн насос станцын тоног төхөөрөмжийн шинэчлэл, УБ хотын 3 байрлалд усны чанар бохирдлыг хянах хяналтын 3 цооног, Сонгинохайрхан дүүрэгт ус зөөврийн 10 машины гараж барих зэрэг барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

- Шугамын трасст орсон айл өрх, бизнесийн байгууллагуудыг нүүлгэн суурьшуулах ажлыг аль болох иргэд байгуулагын эрх ашгийг хөндөхгүй, барилгын ажлыг зогсоохгүй байхаар зохион байгуулсан

Дараах нэр төрлийн тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлсэн.

- Нийслэлийн 6 дүүргийн иргэдтэй .......... удаагийн уулзалт зохион байгуулж, тухайн нутаг дэвсгэрийн ус хангамж, дэд бүтцийн өнөөгийн байдлын судалгааг хийлгэсэн.

- Иргэдээс гарч байгаа санал санаачлагыг дэмжих, төслийн үйл ажиллагаатай холбох, иргэдийн өөрсдийн оролцоогоор орчин тойрны бичил дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө гаргахад туслах зэрэг ....... компанит ажил зохион байгуулсан.

- Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэст хогны 5 тн-ын даацтай 2 машиныг хүлээлгэн өгсөн.

- Тайваны буддын Та Шин Сан-тай холбоо тогтоон төсөл бэлтгэн хүсэлт тавьсны дагуу нийслэлийн 7 дүүргээс тодорхойлсан нийгмийн эмзэг хэсгийн 1000 өрх, 4 байгууллагад 25.5 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний тусламж 30 сая төгрөгийн бүхий хувцас, хичээлийн хэрэглэлийн тусламж үзүүлсэн

Манлайлах ур чадвар, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилтын талаар

- Голландын засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Нийслэлийн байгаль хамгаалах газрын 2, ТУН-ийн 1 ажилтныг Хөх хотод байгаль орчны чиглэлээр 14 хоногийн сургалтад хамруулсан

**7. Бусад байгууллагуудтай хамтран ажилласан болон менежментийг боловсронгуй болгох талаар**

Òº ñëèéí ºìíº òàâüñàí çîðèëòûã õóãàöààíä íü àìæèëòòàé ýðýãç¿ëýõýä õîëáîãäîõ áàéãóóëëàãà, õàìòîëîí ¿æëöýòãýã÷èäòýé õàìòðàí àæèëëàõ, õ¿í á¿ðèéí èäýâõ ñàíàà÷ëàãûã ºðí¿¿ëýõ, ìýäëýã áîëîâñðîëîî äýýø¿ëýõ ýðìýëçëýëèéã äýìæèõ ÷èãëýëýýð îäîðõîé àæëóóäûã çîõèîí áàéãóóëàí àæèëëàñàí

- Òåíäåðèéí õóóëèéí äàãóó øààðäëàãàòàé òåíäåðèéí çàðëàëûã Ñàíãèéí ÿàìíû Âýáñàéòàä áàéðëóóëàõ, ÑØÁÁ -ûã õÿíóóëàõ æàç ººðºë àâàõ, үнэлгээний хорооны шийдвэрт Сангийн яамнаас

çº âøººðºë àâàõ, çºâëºëãºº, ëàâëàãàà àâàõ, өгсөн зөвлөмжийн дагуу íýìýëòìàòåðèàëûã áýëòãýõçýðãýýð Ñàíãèéí ÿàìòàé õàìòðàí àæèëëàñàí

- Зээлийн хөрөнгөөр барьж байгуулсан болон ханган нийлүүлсэн ажил, бараа үйлчилгээг нийслэлийн холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгуулсан.
    - Ус зөөврийн 10 машины гаражийг зээлийн хөрөнгөөр барьж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт бүртгүүлж, Ус сувгийн удирдах газар хүлээлгэн өгсөн.
    - Мөн 5 тн-ийн даацтай ус зөөврийн 10 машин, 2-5тн-ийн даацтай бохир усны 5 машиныг сэлбэг хэрэгслийн хамт УСУГ-т хүлээлгэн өгсөн.
- Hèéñëýëèéí Зàñàã äàðãûí тамгын газраас зохион байгуулсан “...........................” сэдэвт өдөрлөгт идэвхтэй оролцон төслийн талаарх бодит мэдээллийг нийслэлийн иргэдэд хүргэх, бусад үйл ажиллагаатай танилцах, төслийг уялдуулах àðãà õýìæýýã ав.
- Òº ñëèéã óäèðäàõõîðîîíä àæëàà òàíèëöóóëàõ, òåõíèêèéí áîëîí áóñàä àñóóäëàà øèéäâýð ãàðãóóëæ,¿íèéã õýðýãæ¿¿ëýõ.
    - Òº ñëèéã óäèðäàõ õîðîîíû õóðëûã 2 óäàà хуралдуулж төслийн удирдах нэгжийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, ирэх оны төлөвлөгөөг батлуулсан.
    - Мөн òº ñ ëèéí õ¿ðýýíä õèéãäñýí çóðàã òºñºë, òºðºë á¿ðèéí судалгааны материалууд, тайлангууд, УБ хотын цэвэр бохир усны мастер төлөвлөгөө, газрын зургууд зэрэгтэй болон барилга байгууламжтай биечлэн танилцах боломжоор хангасан.
- Äýëõèéíáàí к болон бусад олон улсын байгууллагуудын төлөөлөгчдийг яам, хотын удирдлага, хүмүүстэй уулзуулах, бодлого чиглэлийг нь ойлгуулах, хÿíàëòûí хэсгийн àæëûí òàéëàí óäèðäëàãûí çàõèäëûã õîëáîãäîõ áàéãóóëëàãûí ¿¿ñò õ¿ðãýõ àæëûã çîõèîí áàéãóóëæ байв.
    - Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулсан “Монголын хөгжлийн зах” нээлттэй өдөрлөгт амжилттай оролцон төслийн талаархи мэдээллийг өргөн сурталчилсан
    - Дэлхийн банкны дэд ерөнхийлөгч болон захирлуудын зөвлөлд төслөөр хийгдсэн болон хийгдэж байгаа ажлуудыг танилцуулав.
- Үнэлгэýíèéõîðîîã áàéãóóëàõàä Çàñãèéí ãàçðûí áîëîí õîòûí õîëáîãäîõ áàéãóóëëàãóóäûí òºëººëºã÷äèéã îðîëöóóëæáàéñàí.

  2007 îíä Íèéñëýëèéí Çàñàã äàðãûí

çàõèðàìææààðíèéò 4 Үнэлгээний хороо áàéãóóëàãäààæ 4 зөвлөх/ã¿éöýòãýã÷èéã øàëãàðóóëàõ õóðàé øèéäâýð ãàðãàæ, íõã үй áîëñîí áîëîí äàõèí çàðëàãäàõ байхгүй байв.

- Òºñëèéí õýðýãæèëòèéí ÿâöàä бүх Гүйцэтгэгчид, ÒÕÍ, ÒÓÍ-èéí õàìòàðñàí àæëûí óóëçàëòûã çîõèîí áàéãóóëæ õýâøñýí.

  Èéì óóëçàëòûã ãýðý¿ðýýõ ñ2 áäîëîî õîíîã¿ð õèéæèðñýí áºãººä 200 7 îíäíèéòäýý 20 гаруй óóëçàëòûã çîõèîí áàéãóóëæ, ãàðñàí ïðîòîêîëûã àâàõ õýðýãæèëòèéí àæèëä õÿíàëò òàâèõ, òîäîðõîé òåõíèêèéí àñóóäëóóäûã øèéäâýðëýæ÷ ãºàá áàéñàí íü áàðèëãûí àæëûí ãðàôèêèéãõóãàöààíä í¿¿ëýõýð¿ýã æ èõýýõýí¿ëõýöºãñºí.

УБ хотын НААСТ Монголд хэрэгжсэний 10 жилийн ойг угтан (i) төслийн хүрээнд хийгдсэн ажлууд, ололт амжилтыг олон нийтэд хүртээл болгох (ii) усны үнэ цэнэ, ач холбогдол, зөв зохистой хэрэглээний талаар бүх шатны хүмүүст ойлгуулах (iii) төслийн хүрээнд хийгдэж байгаа барилгын ажлыг эрчимжүүлэх, чанар, аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор дараахи олон талт үйл ажиллагааг авч хэрэгжүүллээ.

- o Төслийг монголд хэрэгжүүлэхэд гар бие оролцсон ахмадууд, гадаад дотоодын зөвлөхүүд, зураг төслийн байгууллагууд, гүйцэтгэгчид, ТУН-ийн ажилтнууд зэргээс дурсамж авч ном болгон хэвлүүлсэн;
- o НАА салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан 3 ажилтныг “НАА-н тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгт тодорхойлж, шагнуулсан. Мөн Нийслэлийн хүндэт дэвтэрт 1 хүнийг бичүүлж, НЗДТГ-ыг жуух бичгээр 1 хүн шагнагдсан.
- o “Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах төсөл 10 нас хүрлээ” баримтат кино бүтээсэн;
- o Гүйцэтгэгч 7 байгууллагын дунд өндөр бүтээлийн 21 хоногийн уралдаан зарлаж, дүнг тусгай комисс байгуулан гаргаж эхний 3 багийг шалгаруулж хонь, ямаа, айраг тэргүүтнээр шагнасан.
- o “Гэр хорооллын хөгжилд бидний оролцоо” сэдэвт гар зургийн болон зохион бичлэгийн уралдааныг Сонгино-Хайрхан дүүргийн 76, 67, Чингэлтэй дүүргийн 37-р сургуулийн сурагчдын дунд зарлаж аваргыг шалгаруулсан. Мөн тэдний мэдлэгийг дээшлүүлэх, төслийн талаархи мэдээлэл өгөх өдөрлөг зохион байгуулсан.
- o Сонгино-Хайрхан дүүргийн 117 –р цэцэрлэгийн багачуудад усны үнэ цэнэ, орчны цэвэр цэмцгэр байдал, төслийн үйл ажиллагааны талаар мэдлэг олгох өдөрлөг зохион

| | |
|---|---|
| | байгуулсан;<br>o Төслийн 10 жилийн хугацаанд хийж бүтээсэн зүйлийн талаар зурагт хуудас, үзэсгэлэн гаргасан.<br>o C1 телевизээр “Ус дуусах уу?” сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдаан зарлаж дүгнэсэн.<br>o Төслийн хүрээнд хамтарч ажилладаг УСУГ, Зөвлөх баг, ТХН-ийн хамт олонтой гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж аваргаа тодруулсан.<br>**8. Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах талаар:**<br>Àæèëòíóóäûí ìýäëýã áîëîâñðîëûã байнга äýýøë¿¿ëýõ, àæëûí çîõèîí áàéãóóëàëòûã ñàéæðóóëàõûí òóëä дараахи ñóðãàëò арга хэмжээнд хамруулсан.<br>• Ажилтнуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Сантис компанитай гэрээ байгуулан ажилласны үр дүнд нийт ажиллагсдын 70 гаруй хувь нь мэргэжлийн англи хэлтэй боллоо.<br>• Сангийн яам, НЗДТГ-аас хамтран зохион байгуулсан олон улсын үндсэн хөрөнгө үнэлгээний сургалтанд 1 хүн, Солонгосын Пусаны үндэсний их сургуульд зохион байгуулсан “Ази дахь олон нийтэд тулгуурласан нийгмийн асуудал” онол практикийн хуралд 1 хүн тус тус хамрагдав.<br>• УСУГ-ын инженер техникийн ажилтнуудтай хамтран ханган нийлүүлэгч байгууллагуудын үйлдвэрлэлд õÿíàëòàâàèõ, шинэ техник технологитой танилцах àæëààðäààâõàðãàñàí òîîãîîð 9 õ¿í ãàäààäàä òîìèëîëòîîð àæèëëàñàí áàéíà.<br>• ТХН-ийн 1, ТУН-ийн 2 ажилтанг Австрали улсад болох төслийн болон санхүүгийн удирдлагын туршлага судлах сургалтад хамрагдсан.<br>• Гүйцэтгэгч байгууллагуудын ажилтнуудыг хуванцар яндан хоолой гагнах (2 аргаар) гагнуурчин бэлтгэх 7 хоногийн сургалтад хамруулж 27 хүнд сертификат олгосон.<br>• ÒÓÍ-èéí 14 ажилтныг ýð¿¿ë ìýíäèéí урьдчилан сэргийлэх үзлэгт хамруул ñíû ¿ð ä¿íä áîëç эрсдлээс 3 ажилтныг хамгаалсан. |
| **Зээл, тусламжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа** | Төсөл хэрэгжилтийн явцад доорхи хэд хэдэн хүндрэлүүд гарч байв.<br>1. Усны үнэ тарифыг нэмэгдүүлэх асуудал нь төслийг хэрэгжүүлэх үндэслэл болж байгаа бөгөөд Монгол улсын |

| | |
|---|---|
| **хүндрэлүүд** | иргэдийн ядуурлын түвшин өндөр байгаатай холбогдуулан аливаа үнэ тарифыг нэмэгдүүлэх нь туйлын эмзэг асуудал болоод байгааг хотын удирдлагууд цохон тэмдэглэж байгаа. Гэвч УСУГ-ын санхүүгийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр боломжийн арга хэмжээг эрэлхийлсээр байна. Тухайлбал: 2007 оны 1-р сарын 1-ээр НӨТ-ийн татвар 5%-иар буурч байгаатай холбогдуулан УСУГ-ын усны үнийг энэ хэмжээгээр нэмэгдүүлэх зөвшөөрлийг олгоод байна. Мөн 2007 оны 4-р сарын 12-ны өдрийн 90-р тушаалаар УТБ-аар иргэдэд түгээх 1л усны үнийг 1000 төгрөг болгоод байна.<br><br>2. УСУГ-ын санхүүгийн хүчин чадлыг бэхжүүлэх, 2 дахь төслийн барилгын ажлыг 67%-ийг санхүүжүүлэх чадвартай байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас (i) УБНААС1 ба УБНААС2-ын төслийн валютын ханшнаас үүсэх эрсдлийг зөрүүг УСУГ-т тооцохгүй байх (ii) 1-р төслийн төлбөл зохих зээлийн эргэн төлөлтийн 2004, 2005 онуудад ноогдож байгаа төлбөрийг 2 жилээр хойшлуулах (iii) Хүүгийн төлбөр хойшлогдсоны торгуулийн мөнгийг хүчингүй болгуулах зэрэг асуудал шийдвэрлэгдээгүй тавьсан ч шийдвэрлэгээдгүй хэвээр байна. Энэ нь 2008 онд хийхээр төлөвлөж байгаа Дарь-Эх Дамбадаржаагийн гэр хорооллын ус хангамжийн барилгын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрт хүндрэл учирч болзошгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.<br><br>3. Мөн иргэдийн оролцоотойгоор олон нийтийн байгууллага байгуулан тэр байгууллагаараа дамжуулан бэрхшээлтэй асуудлаа шийддэг практик Монголд хараахан дэлгэрээгүй байгаа нь энэ чиглэлийн төслийг хэрэгжүүлэхээр оролдож байгаа ТУН-ийн хувьд бас л шинэлэг байв. Иймээс ТУН-ийн ажилтнуудыг, иргэдийн төлөөллийг сургалтанд хамруулах зайлшгүй шаардлага гарч байлаа.<br><br>4. Урьдчилсан зураг төслөөр тодорхойлогдсон ус хангамжийн барилга байгууламж баригдах газрууд өөр зориулалтаар олгогдсоор байна. Нүүлгэн суурьшуулах айл өрхийн тоо судалгаагаар 48 байсан бол 2007 оны жилийн эцсийн байдлаар энэ тоо 189 болж байна. Ингэснээр хотоос санхүүжүүлэх нүүлгэн суурьшуулалтын зардал өсч, улмаар барилгын ажил гүйцэтгэгч байгууллагуудад болон энэ ажлыг гардан зохион байгуулж байгаа ТУН-ийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэнд ихээхэн хүндрэл учирч байна. |
| **Дүгнэлт** | 2007 он бол “Их бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх” жил байлаа. ТУН-ийн энэ зорилгыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа. Гүйцэтгэгч байгууллагуудад ажлын байр нэмэгдүүлэх үүрэг өгч гэр хорооллын ажилгүй ………… иргэдийг барилгын туслах ажилд дадлагажуулж, ажлын байраар хангав.<br><br>Төслөөр хийгдэх барилгын ажлын 50-иас дээш %-ийг эхлүүлж, хөрөнгө зарцуулалтыг ………… хувьд хүргэв.<br><br>Яам, хотын бодлого шийдвэртэй төслийн үйл ажиллагааг уялдуулахад анхаарч Нийслэлийн замын газар, Хотын хөгжлийн |

| | |
|---|---|
| | бодлогын газартай ойрхон ажиллаж ирлээ.<br><br>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө үндсэндээ биелсэн ба УСУГ-ын бодлого, чиглэлээс хамаарсан тоолуурын гэрээ, лабораторын тоног төхөөрөмж худалдан авах гэрээнүүд хойшлогдоод байна. |

# 2007 ОНД БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХИЙГДСЭН АЖЛУУД

| **2. Японы нийгмийн хөгжлийн сан (ЯНХС)-ийн буцалтгүй тусламж-TF 053820** | |
|---|---|
| **Буцалтгүй тусламжийн нэр:** | "Иргэдийн оролцоотойгоор гэр хорооллын орчны дэд бүтцийг хөгжүүлэх" |
| **Зорилго:** | • Олон нийтийн оролцоонд тулгуурласан гэр хорооллын бичил дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө зохиож хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бие засах газрыг барих, бичил зээлийг хөгжүүлэх. |
| **Хөрөнгийн хэмжээ:** | • 1.8 сая ам.доллар |
| **Хэрэгжих хугацаа:** | • 2005-2008 он |
| **Бүрэлдэхүүн хэсэг:** | • Иргэдийн дунд өөртөө туслах бүлгүүдийг байгуулах<br>• Иргэдийн оролцоотойгоор орчноо хөгжүүлэх төлөвлөгөөг зохиох, бодит ажил болгон хэрэгжүүлэх<br>• Агааржуулалттай, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг барих, эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулах, бичил зээлийг хөгжүүлэх |
| **Хийгдсэн ажлууд:** | Буцалтгүй тусламжаар ТУН дараахи ажлуудыг хийлээ.<br><br>"Олон нийтийн оролцоонд тулгуурласан дэд бүтцийн хөгжил" төслийн Зөвлөхийн үйлчилгээний багийг шалгаруулав.<br><br>Сонгон авсан 7 гэр хорооллын иргэдээс 28 олон нийтийн идэвхжүүлэгчдийг сонгон 6 удаагийн сургалтанд хамруулж бэлтгэсэн.<br><br>Идэвхижүүлэгчдийн санаачлага, орон нутгаа хөгжүүлэх оролдлогуудыг дэмжих зорилгоор АПУ ХК-ийн "Амьдрах орчноо сайжруулцгаая", Дэлхийн банкны "Монголын хөгжлийн зах" төслийн уралдаанд хандан төсөл бичихэд нь зөвлөгөө өгч ажилласан.<br><br>Төслийн талаарх үндсэн мэдээллийг иргэдэд олгох, орчныхоо бичил дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн саналыг судлах, нэгтгэх зорилгоор 19 удаа олон нийтийн уулзалт, иргэдийн нийтийн хурлуудыг цуврал болгон зохион байгуулсан.<br><br>"С1" телевизтэй хамтран "Бидний мэдэхгүй Улаанбаатар" нэвтрүүлгийг "Олон нийтийн оролцоотой дэд бүтцийн хөгжил" сэдвээр бэлтгэн нийтийн хүртээл болгосон. |
| **Дүгнэлт** | ЯНХС-ын буцалтгүй тусламжийн хэрэгжилт зогсонги байдалд байсныг нөхөн хийж, буцалтгүй тусламжийг хугацаанд нь бүрэн дүүрэн ашиглахад онцгой анхаарч байна.<br><br>Гэр хорооллын иргэд өөрсдөө зохион байгуулалтад орж, амьдарч буй орчноо өөрсдийн санал санаачлагаар хөгжүүлдэг, төлөвлөлтийг доороосоо дээшээ хийдэг туршлага тус улсад хараахан хөгжөөгүй, мэргэжсэн байгууллага, мэргэжилтэн дутмаг байгаагаас гадна иргэдийн мэдлэг, санаачлага, идэвхи муу байгаа нь ажилд хүндрэл учруулж байна. |

| 3. 2008 онд хийхээр төлөвлөж байгаа ажил /Зээл, тусламж бүрээр/ | |
|---|---|
| | **Нэг. УБ хотын НААС II төслийн хүрээнд:** <br><br> Баянхошууны гэр хороололд баригдах 1500, 500 м3-ийн хүчин чадалтай 2 усан сан, насос станцын 2 барилгыг барьж байгуулах ажлын тендерийн баримт бичгийг бэлтгэн зарлаж, 2008 оны 5 сард барилгын ажлыг эхлүүлнэ. <br><br> Дэлхийн банкнаас хийх дунд шатны үнэлгээнд бэлтгэж төслийн өртөг зардлын хуваарилалтыг дахин хийж ТУХ-нд танилцуулж Дэлхийн банкаар батлуулна. <br><br> Дарь-Эх Дамбадаржаагийн гэр хорооллын ус хангамжийн барилга байгууламжийг барьж байгуулах гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулах, зөвшөөрөл авах, зарлах, үнэлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж 2008 оны 5 сард ажлыг эхлүүлнэ. (УСУГ-ын санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр) <br><br> Төслийн томоохон бүрэлдэхүүн хэсгийн нэг “Эрчим хүчний хэмнэлт”-ийн дор хийгдэх ажлын хэрэгцээ, өртөг зардлын тооцоог Зөвлөхийн багаар тодорхойлуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн гаргана. Мөн энэ хүрээнд хийгдэх зарим нэг ажлыг эхлүүлнэ. <br><br> Телеметрийн системийн ханган нийлүүлэлт, угсралтын ажлын тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг тодруулан ажилд нь оруулна <br><br> Хотын шугам сүлжээнд даралт, урсац тохируулах хаалт суурилуулах ажлын тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж ажилд нь оруулна. <br><br> Лабораторын тоног төхөөрөмжийг ханган нийлүүлж, угсрах, тохируулах ажлын тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж ажилд нь оруулна. <br><br> Гэр хорооллын цэвэр усны шугам сүлжээнд 400 айл өрхийг холбох ажлыг эхлүүлнэ. Энэ ажлыг эхлэхийн өмнө иргэдийн дунд нийгмийн судалгаа хийх, тухайн байршилд тохирсон техникийн шийдэл гаргах, хотын бодлого шийдвэртэй уялдуулан ажлын зураг гаргах, тендер зарлаж гүйцэтгэгчийг тодруулах, ашиглагч байгууллагыг тодорхойлох, журам боловсруулах зэрэг ажлыг Зөвлөхийн багтай хамтарч шийдвэрлэнэ. <br><br> Зөвлөхийн баг, УСУГ, ТХН-тэй хамтран хотын шугам сүлжээг шинэчлэн засварлах, доторлох технологийн шийдлийг эцэслэн шийдэж тендерийн баримт бичгийг дахин боловсруулна. <br><br> Баянхошуу, Чингэлтэйн гэр хорооллын шугамын барилгын ажлыг дуусган, туршилт тохируулгыг хийж ашиглалтанд хүлээлгэн өгнө. <br><br> Мөн Чингэлтэйн усан сан, насос станцын барилгын |

| | |
|---|---|
| | ажлыг дуусган, туршилт тохируулгыг хийж ашиглалтанд хүлээлгэн өгнө.<br><br>Баруун дүүргийн насосны станцын насос шинэчлэн суурилуулах ажлыг дуусгаж УСУГ-т хүлээлгэн өгнө. |
| | **Хоёр. Японы Нийгмийн хөгжлийн сангийн хүрээнд:**<br><br>2.1 Олон нийтийн оролцоонд тулгуурласан төлөвлөгөөг боловсруулах арга зам, хэрэгжүүлэх үйл явц, олон нийт, дүүргийн оролцоог дайчлах төлөвлөгөөг нарийн тусгасан гарын авлага боловсруулна.<br><br>2.2 Гарын авлагыг иргэд олон нийт, дүүрэгт танилцуулах, сурталчлах ба холбогдох сургалтыг зохион байгуулна.<br><br>2.3 Иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, олон нийтийн байгууллагуудыг чадваржуулах ажлыг зохион байгуулна.<br><br>2.4 Сонгогдсон хороодын дэд бүтцийн хөгжлийн хэрэгцээг олон нийтийн санаа бодол, оролцоонд тулгуурлан тодорхойлох, эрэмбэлэх, төлөвлөх ажлыг зохион байгуулна.<br><br>2.5 Шаардлагатай төсвийн 80 хувийг буцалтгүй тусламжаас, дүүрэг болон олон нийт тус бүр 10 хувийн хөрөнгө оруулалтыг гаргаж хамтын ажиллагаа, хяналтын хүрээнд төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.<br><br>2.6 Барьж байгуулсан нийтийн үйлчилгээний объектуудын тасралтгүй ажиллагаа, тогтвортой байдлыг холбогдох дүүрэг болон олон нийт хариуцах, хамтран ажиллах энэ чиглэлээр чадваржуулна.<br><br>2.7 Эрүүл ахуйн сургалтанд иргэд, олон нийтийг хамруулна.<br><br>2.8 Хямд өртөг бүхий ариун цэврийн байгууламжийг байгуулахад зориулагдсан эргэлтийн сан (Revolving Fund) байгуулах, иргэд, өрхүүдэд зээл олгох ажлыг эхлүүлнэ.<br><br>2.9 Төслийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлгэнэ |